

лагдан, хувьсгалын үед зохиосон бусад толь бичгүүдэд нөлөө үзүүлсэн билээ.

³ Хауан-nu bičigsen manju mongyol ugen-nu toli bičig, Энх-Амгалангийн тавин зургадугаар (1717) он, бар, Бээжин. оршил

⁴ Дурдсан зохиол

⁵ Хауан-nu bičigsen manju mongyol ügen-nü toli bičig, Тэнгэрийн тэтгэсний наймдугаар (1746) он, бар, Бээжин.

⁶ Шагж, дурдсан зохиол, 722 а,

⁷ Хауан-nu bičigsen manju mongyol ügen-nü toli bičig, Цаг улиралын зүйл, тавдугаар

⁸ Шагж, дурдсан зохиол, 1 в

⁹ Шагж, дурдсан зохиол, 2 а

¹⁰ Шагж, дурдсан зохиол, 683 а

¹¹ Шагж, дурдсан зохиол, 684 в

¹² А. Лувсандэндэв. Хэл бичгийн ухааны зарим асуудал, 1, УБ. 1982. 107—109

¹³ А. Лувсандэндэв, дурдсан зохиол, 131-р тал

¹⁴ Шагж, дурдсан зохиол, 2 в

¹⁵ Шагж, дурдсан зохиол, 576, 286, 2 а, 2 в, 266 а,

¹⁶ Шагж, дурдсан зохиол, 107 в

¹⁷ Шагж, дурдсан зохиол, 266 в

¹⁸ Шагж, дурдсан зохиол, 681 а

¹⁹ Шагж, дурдсан зохиол, 681 в

²⁰ Шагж, дурдсан зохиол, 687 а

²¹ Шагж, дурдсан зохиол, 2 в

²² Я. Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, УБ. 1966. 15-р тал

²³ Древнетюркский словарь Л., 1969, с. 510

²⁴ К. К. Юдахин, Киргизско-русский словарь, М., 1965, 659

²⁵ Русско-узбекский словарь, под редакцией Р. Абдурахманова, М., 1954, с. 748

²⁶ Б. Базылхаан, Казах-монгол толь УБ., 1977, 222-р тал.

²⁷ Э. В. Севортян, Африксы глаголообразования в азербайджанском языке, М., 1962,

с. 312

²⁸ Шагж, дурдсан зохиол, 809 в

ГУРВАН МАНДАЛЫН ТҮРЭГ БИЧЭЭС

Л. БОЛД

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн

Р. БЯМБА

БНМАУ-ын нутагт буй хад чулуунаа сийлж үлдээсэн бичиг үсгийн дурсгалууд бол өнөөгийн бидэнд уламжлагдан ирсэн эдийн болон оюуны соёлын зүйлсийн адил Төв Азийн нүүдэлч түмний соёл, түүхийг судлах үнэт хэрэглэгдэхүүн юм. Үүнийг манай ард түмэн сайтар ухамсарлан, хайрлан хамгаалах талаар үлэмж анхаарч ирсний нэг тодорхой баримт бол түүхийн чухал мэдээт газар орныг «Бичигт хад», «Бичигт хошуу» гэх мэтээр эрхэмлэн нэрлэж хойч үеийнхэндээ заан уламжлуулан ирсэн явдал юм. Иймээс бичиг дурсгалыг анх нээгчид нь

нутгийн ард түмэн, шинжлэх ухааны хүмүүс бол тэр зүйлийг нарийвчлан судлагчид байдаг билээ.

Энд нутгийн ард түмэн эхлэн нээж шинжлэх ухааны хүмүүст сонордуулан, улмаар эрдэм шинжилгээний эргэлтэд оруулж буй нэгэн бичээсийн талаар товч өгүүлэх болно.

1. 1987 оны 8—9-р сард БНМАУ-ын ШУА-ийн Дорнод ахины хүрээлэнгээс явуулсан «Төв Азийн нүүдэлчин ард түмний түүх соёл»-ыг судлах шинжилгээний ангийнхан ажлынхаа удирдамжинд заасан зүйлийг гүйцэтгээд буцах замдаа Баянхонгор аймгийн Бууцагаан сумаар орж нутгийн ардуудаас хадны зураг, бичигтэй хад чулууг сурвалжилсан билээ. Тэгэхэд «Чачиртын ам»-ны хадан дээр улаан зоосоор бичсэн бичиг буй, бас «Гурван мандал»-ын «Эхэн мандал», «Дунд мандал»-ын хаданд янгир, аргаль, буга зэрэг янз бүрийн амьтны дүрс бий гэж нутгийн хүмүүс ярьсан юм. Энэ чухал мэдээг шалгахаар «Чачиртын ам»-нд очиж үзвэл энэ нь бидний төсөөлж явсан эртний ямар нэг бичиг биш улаан зоосоор том жижиг янз бүрийн хэмжээтэй бичсэн маанийн үсэг байсан тул тэндээсээ «Гурван мандал»-ыг чиглэн явав. Гурван мандал уулыг алсаас харахад хүн хэргээр засаж тэгшилсэн юм шиг орой нь хавтгай, хойноосоо урагшаа цувран шил шилээ харан тогтсон маш сонин тогтолцоотой гурван адил уул юм. Энэ нь Бууцагааны төвөөс зүүн тийш 45—50 км зайтай, IV бригадын нутаг Мандалын голын сав дагуу оршдог. Тэнд хоёр хэсэг газар эртний түрэг үсгээр бичсэн бичээс байсан бөгөөд бид түүний гэрэл зургийг авч, нарийн хэмжилт хийв**.

«А» бичээсийн тухай

Энэ бичээсийг «Дунд мандал»-ын баруун урд талд урагшаа харсан хадны дунд хирд, доор хоёр хэсэг болгон 3 мөр бичжээ. Нэгдүгээр хэсэг буюу уг хадны дээд талд байгаа бичээсийн үсгийн өндөр 5 см, хоёрдугаар хэсэг буюу хадны доод талын бичээсийн үсгийн өндөр 5, 6 см орчим байна. Уг бичээсийг бусад түрэг бичигтэй хөшөөний адилаар хурц үзүүртэй зүйлээр хонхойлгож бичсэн, гүний хэмжээ 1 мм орчим болно.


«Б» бичээсийн тухай

Энэ бичээс нь «Адаг мандал»-ын зүүн урд талд зүүн урагшаа бөхийсөн хүний анхааралд төдий л амархан өртөмөөргүй жижгэвтэр чулуу ны элгэн талд байна. Бичээсийг чулууны дундаас дээгүүрхэн мөн гурван мөр болгон бичсэн байна. Мөрийн урт нь 40 см, үсгийн өндөр нь 3 см, бичээсийг хурц үзүүртэй зүйлээр зурж бичсэн тул үсгийн гүнийг хэмжих боломжгүй юм.

II. Уг бичээсийг гэрэл зургаас нь буулган үзүүлбэл:

* — Уг шинжилгээний ангид Дорнодахины судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан С. Дашцэвэл, Р. Бямбаа, Баянхонгор аймгийн 18-р баазын жолооч Б. Дэмбэрэл, зурагчин Г. Ганзориг нар оролцжээ.

** Уг бичээсийн гараар буулгасан хуулбар (Р.Б.), гэрэл зургийг (Г.Г.) ДДСХ-ийн шинжилгээний ангийн материалд бий.



III. Энд сийрүүлсэн үсэг зурлагуудыг авч үзвэл: «А» бичээсийн 1 мөрөнд орсон гурван үсэг их л тодорхой учир үүнийг **т (1) б (2) з** гэж Мөн хоёрдугаар мөрөнд орсон гурван үсгийг **к (1) ы (-и) с (2)** гэж үсэгчлэн буулгана. Харин III мөрөнд орсон 1-р үсэг нь эм үгэнд ордог зөөлөн **р (2)**, 2-р үсэг нь эр үгэнд ордог гэхдээ енисейн бичээсүүдэд ихэвчлэн тохиолддог **т (1)** байна. Иймд уг хоёр үсэг бол тус тусын биеэ даасан үг болно гэж үзвэл дараагийн зурлага нь бидний бодлоор нэг үсэг тухайлбал **м** үсэг байж болох байна. «А» бичээсийн бусад үсгүүд их л тодорхой учир тухайлсан тайлбар шаардлагагүй буй заа.

«Б» бичээсийг гэрэл зургаас үзвэл уг бичээсийн үсэг-зурлага нилээд гэмтэлтэй, у: бичээс бидэнд бүрэн гүйцэд уламжлагдан ирээгүй болох нь тодорхой байна. Харин орхон бичгийн үсэг зурлагатай харьцуулан үзвэл өвөрмөц буюу тухайлбал талаас, енисейн бичгүүдэд гардаг өвөрмөц зүйл бараг байхгүй байна. Иймд үүнийг дор дурдсанаар сийрүүлэн буулгаж болно.

«А» бичээс
«Б» бичээс

	ХУС	I
	ИМН	II
	ҮМҮҮД: ХУС	III
	ҮХУС	IV
ҮҮҮ	ХУСЧН: ХМНВҮЧ	V
ЛХҮЕ	КНН: УСДХУС	VI

IV. Уг үсэг зурлагыг галигчлан буулгавал:

«А» бичээс I. т (2) б (1) з

II. к (1) ы (—и) с

III. р (2) т (1) м л (1) нг ч ы (—и) к (1)

«Б» бичээс I. т (1) м д (2) р (2)

II. н (2) ч к (2) к (1) ы (—и) з к (1)

р (1) г (1) з л (2) нг к (2)

III. т (1) о (—у) м л (1) г (1) т (2) ө (—ү) р (2)

к (2) г (2) л (2) т (2) а (—е)

V. Зарим үгийг үгийн сан-хэлзүйн үүднээс тайлбарлан үзье. «А» бичээсийн Ш мөрөнд 1—3 үсэг зурлагын талаар өмнө тайлбарласан билээ. 4—8-р үсгүүд бол бүгд чанга буюу эр үгэнд ордог гийгүүлэгч, эгшиг байна. Харин энд 6-7-р үсэг зурлагуудыг чухам ямар үсэг вэ гэдэг нилээд маргаантай байж болно. 8-р үсэг нь зөвхөн эр эгшигт үгэнд ордог к байна. Иймд үүнийг бид ер атым о-уло-унчык гэж үсэгчилэн буулгав. Үүний ер гэдэг бол эртний орхон бичгийн дурсгалд арвин тохиолддог, тухайлбал бидний гарт буй орхон бичгийн дурсгалуудад **ер —ерин** гэсэн хоёр янз бичлэгтэй байдаг. **алп ерин өлүрип ...** (Бха. 7) «Баатар эрсийг (нь) үхүүлж (сөнөөж)», **челги Аз ер болтым...** (Тон. 7) «Цөлийн Аз эр билээ би», Энэ хоёр хэлбэрийн утгын талаас нь үзвэл эр «эр» нь ганц тоог, эрин «эрс» гэдэг нь олон тоог үлгэрлэвэл, өд «цаг хугацаа, үе» (Ж нь: **Турш Билге каган бу едке олуртым**) Түрэг Билэ би энэ цагт хагаан суув (Кт. б. 1)) гэдэг үг олон тооны хэлбэрт орон өдүс —өдүш (Жнь **...түнли кунли ийти өлүшке субсыз качдым**).. долоо хоног өдөржин, шөнөжин усгүй тууллаа (Б. XII)" гэсэн хоёр янз тохиолддогтой адил юм. Эртний түрэг бичээст **ат «нэр, нэр алдар»** гэдэг үг олон тохиолддог. Бидний судалж буй уг бичээст энэ үг нь нэгдүгээр биеийн ганц тоонд хамаатуулах нөхцөл авч, ингэснээрээ уул нэрийн дор өгүүллэгдэх олон төрлийн зүйлээс уг нэрийг онцлон өөрөөр хэлбэл ялгах ёс-ыг илтгэж байна. о (у) л—о (у) учык-Эртний түрэг бичиг болон, орчин цагийн ихэнх түрэг хэл аялгуунд үгийн нэгдүгээр үеэс

хойш **о. ө** авиа ордоггүй учир үүнийг **олунчык-улунчик** гэж галиглах нь зүйтэй биз. Энэ үг БНМАУ-ын нутагт буй эртний орхон бичгийн дурсгалд ер тохиолдохгүй, харин уг бичигтэй гарлынхаа талаар шууд холбоотой енисейн бичигт **улунг-улунг шад** гэдэг нэр цолын үүрэгтэй (ДТС. 610) тохиолдож байна. Энэ үг уг бичээст ийм л үүрэгтэй байна.

Хун тайж Күл-тегинд зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээст... **иним күл-тегин ерат болты** «бага дүүд минь Күл-тегин нэр өргөмжлөв. — бага дүү минь Күл-тегин гэдэг өргөмж нэртэй болов) Кт. 31» гэсэн өгүүлбэр байна. Энэ өгүүлбэрт буй **ер** ат гэдэг холбоо үг нь бидний судалж буй бичээст тохиолдож буй үгтэй яг адил утгатай, иймээс уг бичээсийг бичигч олунчык-улунчык гэдэг нэрд өргөмжлөгдсөн хүн болох нь тодорхой юм. Харин уг хүн тухайн цагийнхаа нийгэмд ямар үүрэг рольтой талаар цаашид гүнзгийрүүлэн судлууштай.

«Б» бичээсийн II мөрөнд буй н (2) чк (2) бол XII-XIV зууны үеийн уйгарын хууль цаазны бичигт тохиолддог **еничүк** гэдэг үг мөн байх. Харин үүний дараа тохиолдох **к (1) ы (-и) 3—г Акыз гэж үзвэл энэ** нь даруй эртний түрэг тольд тэмдэглэсэн, мөн бидний судалж буй бичээсийн «А» хэсгийн II мөрөнд буй **Акыс** гэдэгтэй адил хүний нэр байж тун болзошгүй. Иймд **еничүк** гэдэг үгийг цол гэж ухаарах боломжтой юм. Мөн мөрд буй **к (1) р (1) г (1) з** бол хун тайж Күлитегин болон, цэцэн Тонькук нарт зориулан босгосон гэрэлт хөшөөний бичээст буй кыргыз гэсэн хэлбэртэй үг мөн. Уг бичигт энэ үгийн хоёрдугаар үгийн эхэнд орсон **к-г-г-ээр** бичсэн нь магадгүй уг бичээсийг Күлитегин, Тонь кук нарт зориулсан хөшөөний үгийг бичсэнээс өөр аялгуугаар тэмдэглэсэн болохын баталгаа болж болох юм. Ингэж үзэхийн өөр нэг шалтгаан, бол уг бичээсийн дотор гарах **акыс акыз** гэдэг үг юм. Эртний түрэг толь, мөн уйгарын үеийн баримт зэргээс үзвэл уул нэрийг акыс гэж бичсэн нь зөв байх. Гэвч уул бичээсийг бичигч хүн цалгардаж **Акыз** гэж 30 риуд алдаа гаргав уу гэтэл тийм биш **с -з** гийгүүлэгч түрэг хэлэнд ихэд сэлгэж хэрэглэгддэг байсан аялгууны нөлөө, өөрөөр хэлбэл уул үгийн эцсийн гийгүүлэгчийг з-ээр хэлдэг аялгуугаараа бичсэн гэж үзэхэд төндий л их алдаа болохгүй буй заа.

VI. Ийм тайлбарт тулгуурлан уг бичээсийн үгийг дор дурдсанаар тоймлон үгчлэн буулгаж болох мэт. Үүнд:

«А» бичээс: **1. ата быз ...**
II. ... Акыс ,,,
III. ер атым Улунгчык (— олунгчык)

«Б» бичээс **1. атым др, ,**
II. еничык Акыз кыргыз елентке
III. ... утумлыг түрк егелте,,,

VII. Орчин цагийн монгол хэлээр орчуулбал; Үүнд:

«А» бичээс: **1. ... эцэг бид,**
2. ... Акыс,, .
3. эр нэр минь Улунгчык

«Б» бичээс: **1. ... нэр минь др.,**
2. еничык Акыз кыргыз улсад...
3. ... Утуйлыг түргийн эгэл түмэнд,

VIII. Уул бичээсийн нэгдүгээр хэсэг буюу «А» бичээс бол хэн нэг хүн Улунгчык нэрд өргөмжлөгдсөнөө мөнхжүүлэх зорилготой бичсэн байна. Харин бидэнд хоёрдугаар буюу «Б» бичээсийн агуулгын талаар

ийм тоймтой зүйлийг баттай хэлэх боломж одоогоор алга юм. Гэвч хоёрдугаар бичээсийг бол Күл-тегин, Тоньюкук нарт зориулсан хөшөөний бичээсийг бичсэнээс өөр аялгуугаар бичсэн нь нилээд тодорхой байна. Хоёр бичээсийг хоёр өөр газар бичсэн байдлаас үзсэн ч, дотор өгүүлэгдэх зүйлийн агуулгаас үзсэн ч бичигдсэн аялгууны байдлаас үзсэн ч энэ нь тус тусдаа зүйл болох нь мэдэгдэж байна. Уг бичээсүүдийн дотор гарах өргөмж нэр, болон бусад нэр, цолын нэрээс үзвэл уг бичээсийг уйгарын хаант улсын үед хамруулан үзэх боломж олгохын гадна уг нэр цолтой хүмүүс тухайн үедээ ямар учир холбогдолтой болохыг гүйцэд нарийн судлахыг биднээс шаардаж, энэ чанараараа ч уг бичээсийн ач холбогдол тодорхойлогдох биз ээ.

ЖАРНЫ ТООЛОЛ

Л. ТЭРБИШ

Дэлхийн улс түмэн христосын буюу аргын, жарны буюу билгийн, хижрийн буюу дан ганц сарны тооллыг хэрэглэсээр иржээ. Христосын он тоолол нь христосын шашинт орнуудад үүсч дэлгэрсэн, нарны хөдөлгөөнд тохируулсан тоолол бөгөөд эдүгээ дэлхийн нийтийн он тоолол болсон байна. Хижрийн тоолол нь лалын шашинт орнуудад үүсч дэлгэрсэн, дан ганц сарны хөдөлгөөнд тохируулсан тоолол бөгөөд хижр 622 онд эхлэжээ. Харин буддын шашинт орнуудад дэлгэрсэн билгийн тоолол нь сар, нарны хөдөлгөөнийг давхар тооцож зохиодог тоолол юм.

Билгийн тооллыг зохиох онолын үндэслэл манай тооллын IX зууны үед Энэтхэг оронд тавигдаж, Төвдөөр дамжин улмаар Монголд нэвтэрчээ. Чингэхдээ Монголчууд нар, сар болон од, эрхсийн хөдөлгөөнийг монгол орны газрын хуваарьт тохируулан тооцох шинэ аргыг буй болгож, түүндээ тулгуурлан цаг тооллын бичгийг зохиосоор ирсэн түүхтэй Билгийн тооллыг аргын тоололтой тохируулахын тулд 3 жилд нэг удаа илүү сар гаргадаг. Өөрөөр хэлбэл билгийн 65 хагас сар буюу 32,5 сар тутамд нэг сарыг нэмж, түүнийгээ илүү сар гэх ба илүү сартай жилийг өндөр жил гэнэ.

- Билгийн тоололд жил, сар, өдрийг таван махбод хавсарсан арван хоёр амьтнаар нэрлэдэг. Язгуур таван махбод нь гал, шороо, төмөр, ус, мод ба арван хоёр амьтан нь хулгана, үхэр, бар, туулай, луу, могой, морь, хонь, бич, тахиа, нохой, гахай гэсэн дараалалтай байна.

Хулгана, бар, луу, морь, бич, нохойг эр; үхэр, туулай, могой, хонь, тахиа, гахайг эм жил гэдэг.

Мөн таван махбодод таван өнгө харгалзуулж 12 амьтнаар жилийг тоолох ёсон буй. Тэгэхдээ галд улаан, шороонд шар, төмөрд цагаан усанд хар, модонд хөх өнгийг харгалзуулна. Өнгө харгалзуулахдаа, эр